



USAID
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС



Эдийн засгийн бодлогын шинэтгэл,
өрсөлдөх чадварын төсөл

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2007 оны 2 дугаар сар

Худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхыг байгуулах ажлын явцтай танилцахаар *Société Générale de Surveillance* компанийн төлөөлөгчид Монголд айлчлав

Уг төслөөс зохион байгуулсны дагуу *Société Générale de Surveillance* (SGS) компанийн гурван мэргэжилтэн худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхыг Монгол улсад нэвтрүүлэх ажлын явцтай танилцаж, тодорхой мэдээлэл авах зорилгоор Монгол улсад ажиллав.

Филипп Ислер, Дэвид Уокер, Крис Хоулден нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид 2 дугаар сарын 20-ны өдрөөс 3 дугаар сарын 1-ний хооронд Монголд зочиллоо. Ноён Ислер Женевт төвтэй SGS компанийн худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхны бүтээгдэхүүн болох TradeNet төслийн менежерээр, ноён Уокер SGS компанийн Арабын Нэгдсэн Эмират Улсын нийслэл Дубай дахь гаалийн мэргэжилтнээр, ноён Хоулден Гана улсад худалдааны цахим нэг цонхны GCNet сүлжээний үйл ажиллагааны менежерээр тус тус ажилладаг юм.



SGS (www.sgs.com) нь 1878 онд байгуулагдсан, дэлхийн олон улс оронд 1000 гаруй салбар, лаборатортой, 43,000 гаруй ажилтантай, хяналт, шинжилгээ, баталгаажилт хийж, гэрчилгээ олгодог дэлхийн тэргүүлэх компани юм. Компани нь дараахь үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

- Бараа, бүтээгдэхүүний тоо, чанар, жинг хянаж, тогтоох
- Бүтээгдэхүүний чанар, үзүүлэлтийг эрүүл ахуй, аюулгүй байдал, зохицуулалтын янз бүрийн стандартын дагуу шинжлэх
- Засгийн газар (ГОСТ Р г.м), стандартчиллын газар (ISO 9000 г.м) эсвэл SGS-ийн хэрэглэгчдийн тогтоосон стандартын дагуу бүтээгдэхүүн, үйлчилгээ, системд гэрчилгээ олгох
- Олон улсын стандарт болон тухайн орны шаардлагыг тухайн бүтээгдэхүүн болон үйлчилгээ хангаж буй эсэхийг хянаж баталгаа гаргах

TradeNet-ийн бүтээгдэхүүн. SGS нь худалдаатай холбогдолтой мэдээллийг цахим байдлаар солилцох боломжийг олгодог TradeNet-ийн бүтээгдэхүүнийг голлон нийлүүлэгч гэдгээр олон улсын хэмжээнд танил болсон компани юм. Тус компани нь Сингапур, Мавритани, Гана, Панам, Саудын Араб зэрэг орнуудад TradeNet сүлжээний янз бүрийн хэлбэрийг санхүүжүүлж, үүсгэн байгуулж, үйл ажиллагааг нь удирдан явуулж байсан ба одоо Кот-д'Ивуар, Мадагаскарт цахим нэг цонхыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

TradeNet-ийн тухай ойлголт нь анх 90-ээд оны эхээр Сингапурт бий болж, CrimsonLogic-той тогтоосон нягт түншлэлийн үр дүнд цахим нэг цонхны жишиг сүлжээ болон олон жилийн туршид хөгжжээ. Программ хангамж нь орон бүрийн нөхцөл байдалд зохицуулан хийсэн загвартай байдаг байна.

Худалдааны цахим нэг цонхыг байгуулахад SGS-ийн гүйцэтгэх үүрэг. SGS компани нь TradeNet-ийг дараах замаар нэвтрүүлдэг. Үүнд:

- Цахим нэг цонхны системийг боловсруулах, хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь явуулах улсын ба хувийн хэвшлийн хамтарсан (public-private partnership буюу PPP), бие даасан компанийг байгуулах
- "Байгуул, ажиллуул, шилжүүл" (Build, Operate, Transfer буюу BOT) загварын дагуу, SGS нь TradeNet-ийг ашиглан цахим нэг цонхныг концессийн журмаар байгуулж, ажиллуулж, дараа нь урдчилан тохирсон хугацаанд системийг шилжүүлэх өгөх
- Шаардлагатай бол суурь хөрөнгө оруулалт хийх
- Цахим нэг цонхны систем болоод компанийн үйл ажиллагаа нь ашгийн төлөө байх ба тогтвортой байдлыг хангах, байнгын шинэчлэлийг санхүүжүүлэх чадвар бүхий нарийн тодорхойлсон орлогын эх үүсвэртэй байх
- Төрийн албан хаагчид, дотоодын бусад хамтран ажиллагсдын чадавхийг дээшлүүлж, тогтвортой байдлыг хангах зорилгоор мэрэгшил, ноу-хауг аажмаар эзэмшүүлж өгөх
- Давхардалтыг арилгаж, зардлыг багасгах зорилгоор одоогийн дэд бүтцийг (ашиглагдаж буй сүлжээ, программ хангамж г.м.) боломжийн хирээр ашиглах.

Худалдааны цахим нэг цонхны ач холбогдол

Худалдааг хөнгөвчлөх TradeNet цахим нэг цонхны сүлжээг нэвтрүүлэх нь засгийн газарт дараах ач холбогдолтой. Үүнд:

- Дүрэм журамд нийцүүлэн худалдаа хийх явдлыг дэмжиж ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлнэ
- Төсвийн орлого эрс нэмэгдэнэ.
- Цаасан бичиг баримтыг байхгүй болгож, ачаа чингэлгийн байршлын талаархи нарийн мэдээллээр хангаснаар боомтуудын найдвартай байдал бэхжинэ.
- Оролцогч төрийн байгууллагуудын чадавхи эрс нэмэгдэнэ
- Худалдааны талаарх мэдээлэл, статистик тоо баримт илүү бодитой, найдвартай болно.
- Засгийн газрын нөөцийг үр ашигтай ашиглана.
- Үр ашигтай цахим засаглалын үндэс суурь болно.

Худалдааны цахим нэг цонх нь худалдаачдад дараах ач холбогдолтой. Үүнд:

- Гаалийн бүрдүүлэлтийг хурдавчилна.

- Давхардалт, алдаа гарах явдал багасна.
- Бичиг баримттай холбогдон гардаг зардал багасна.
- Төрийн байгууллагуудтай нэг цэгээр дамжуулан, 24 цагийн турш мэдээлэл солилцох боломж бүрдэнэ.
- Статистикийн үнэн зөв мэдээлэл авах боломжтой болно.
- Мэдээллийн системийн талаарх мэдлэг, чадвар сайжирна.

Цахим нэг цонхыг амжилттай хэрэгжүүлж буй SGS-ийн туршлагаар дараах зүйлсийг амжилтад хүрэх гол хүчин зүйлс гэж тогтоожээ. Үүнд:

- Засгийн газраас тууштай дэмжлэг үзүүлэх
- Төслийн менежментэд хувийн салбарыг оролцуулах
- Онцгой чадвар бүхий, бие биенээ нөхөн дэмжих боломжтой түншүүдийг тэнцвэржүүлэн сонгох
- Төсөл хэрэгжинэ гэдэгт гол оролцогчид бат итгэлтэй байх
- Өөрөө өөрийгээ санхүүжүүлэх санхүүгийн загвартай байх
- Тухайн орны нөхцөлд тохирох нь батлагдсан технологийг нэвтрүүлэх

SGS-ийн төлөөлөгчдийн Монгол улсад хийсэн айлчлал

SGS-ийн мэргэжилтнүүд нь цахим нэг цонхны ажлын хэсгийн гишүүд, холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүд, хувийн хэвшлийнхэнтэй шахуу цагийн хуваарийн дагуу биечилсэн уулзалтуудыг зохион байгууллаа. Уулзалтад дараахи хүмүүс оролцов:



- Ч. Сайханбилэг, Мэдээлэл, харилцаа холбооны технологийн газар (МХХТГ)-ын дарга бөгөөд Ажлын хэсгийн ахлагч
- Г. Гантөмөр, Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв (ҮСХЗТ)-ийн дарга
- Б. Энхмандах, Байгаль орчны дэд сайд
- Ж. Энхбаяр, Улсын мэргэжлийн хяналтын газар (УМХГ)-ын орлогч дарга
- С. Алтангэрэл, Улсын гаалийн ерөнхий газар (УГЕГ)-ын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга бөгөөд Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
- Д. Дариа, Улаанбаатар хотын Гаалийн газрын дарга
- Б. Лхагвадорж, Гаалийн хяналтын хэлтсийн албаны дарга
- П. Батхуяг, Олон улсын тээвэр зуучлалын компанийн ерөнхий захирал
- УГЕГ, МХХТГ, УМХГ, ҮСХЗТ, Үйлдвэр худалдааны яам, Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын техникийн ажилтнууд
- Тээвэр зуучлалын компани ба гаалийн брокерууд

SGS компанийн төлөөлөгчид худалдааны цахим нэг цонх, TradeNet сүлжээ, түүнийг хэрэгжүүлэхэд SGS-ийн гүйцэтгэх үүргийн талаар 2 дугаар сарын 27-нд олон нийтэд илтгэл тавьлаа. Уг арга хэмжээг ЭЗБШӨЧ төсөл ба *Нээлттэй нийгэм форум*аас ивээн тэтгэв. Илтгэлийг англи, монгол хэл дээр ЭЗБШӨЧ төслийн (www.eprc-chemonics.biz) вэб сайтаас үзэх боломжтой.

Цахим нэг цонхны үйл ажиллагаанд оролцогч талуудтай 7 хоногийн туршид уулзаж ярилцсаныхаа дараа "худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхыг Монгол улсад байгуулах талаар сүүлийн 6 сарын хугацаанд оролцогч талууд их зүйлийг хийсэн байгаад бид маш өндөр сэтгэгдэлтэй байна" гэж TradeNet төслийн менежер Филипп Ислер онцлон тэмдэглэлээ.

Ажлын хэсэг үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэхийн зэрэгцээ, нарийн дүн шинжилгээнүүдийг хийх шаардлага гарч байна, ирээдүйд худалдааны цахим нэг цонхыг Монгол улсад хэрэгжүүлэх улсын ба хувийн хэвшлийн хамтарсан компани байгуулах тал дээр харилцан ашигтайгаар хамтран ажиллахад SGS компани бэлэн байна гээд "хэрэв энэ зорилго хэрэгжвэл Монгол улс иймэрхүү системийг Төв Азид нэвтрүүлсэн анхны орон болох юм" гэж мэдэгдлээ.

Дараагийн алхмууд

2006 оны 12 дугаар сарын 18-нд болсон Ажлын хэсгийн уулзалтаар шийдвэрлэсний дагуу Худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхыг байгуулах тухай үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулахад ЭЗБШӨЧ төслөөс туслалцаа үзүүллээ.

Холбогдох яам, агентлагуудаас санал авахаар хөтөлбөрийн төслийг хүргүүлэх ажлыг МХХТГ-аас зохион байгуулав. Хөтөлбөрийг 2007 оны эхний улиралд Засгийн газарт өргөн барихаас өмнө Ажлын хэсгийн дараагийн хурлаар хэлэлцэхээр тохиролцов. Уг хөтөлбөрт цахим нэг цонхыг хэрэгжүүлэх гол зарчмуудыг зааснаас гадна уг ажлыг удирдан явуулах улсын ба хувийн хэвшлийн хамтарсан компани байгуулах тухай санал тусгагдсан байна.

Цахим нэг цонхыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, SGS компанийн тавьсан хүсэлтийн дагуу сүүлийн гурван жилд хийсэн худалдааны транзакцийн мэдээг нэгтгэх ажлыг гаалийн газартай хамтран тус төсөл гүйцэтгэхээр болов.

Монгол улсад үйлдвэрлэсэн нэрсний чанамал Японы зах зээлд гарахад бэлэн боллоо

Нэрсний чанамал экспортлох тухай санал анх гарснаас хойш нэг жилийн дараа буюу энэ оны 2 дугаар сарын 27-нд нэрсний чанамалын эхний чингэлгийг Япон улс руу ачлаа. Энэхүү арга хэмжээ нь дотоодын үйлдвэрлэгч "Бенедакт" компани, Японы эрүүл хүнсний бүтээгдэхүүний импортлогч, дистрибьютор "Pacific Trading" компаниудыг холбох талаар уг төслөөс гаргасан хүчин чармайлтын үр дүн юм.



Нэрсний боломжит зах зээл Японд буйг манай төслийн ажилтнууд 2005 оны сүүлээр анх олж мэдсэн юм. Үл эсэлдүүлэгч бодисоор баялаг нэрс жимс нь анагаах

чанараараа танил бөгөөд ялангуяа эрүүл мэнддээ анхаарал тавьдаг Япончуудын дунд эрэлт хэрэгцээтэй жимс юм.

Бенедакт ХХК нь жимсний чанамал ба жүүс үйлдвэрлэдэг, хэрэглэгчдэд танил болсон компани юм. Тус компанийг Японы зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэх боломжтой гэж уг төслөөс үзэж, 2006 оны 5 дугаар сард ЭЗБШӨЧ төслийн урилгаар Японы импортлогчдын төлөөлөл болох 2 бизнесмен Монгол улсад айлчилсан. Тэд нэрс ургадаг нутгийн хойд хэсгээр явж, үйлдвэрлэл явуулдаг нөхцөлтэй танилцсан юм. Айлчлалын төгсгөлд Pacific Trading компани 2006 оны эцсээр эхний нийлүүлэлтийг хийх нөхцөлтэйгээр нийт 60,000 шил нэрсний чанамал худалдан авах захиалгын гэрээнд гарын үсэг зурсан.

Нэрсийг 8 дугаар сараас эхлэн түүж эхэлсэн бөгөөд нэрс боловсруулах үйлдвэрийн ажлын явцтай танилцаж, үйлдвэрлэл ба чанарын талаар зөвлөгөө өгөхөөр Японы хүнсний технологид 9 дүгээр сард Монгол улсад ирж, Японы стандартыг хангахын тулд хэд хэдэн зүйлийг анхаарч, гарч буй доголдлыг арилгахыг зөвлөв. Жимсийг ишнээс салгах ажиллагаа нь хүндрэлтэй дамжлага байсан. Хэдийгээр дотоодын зах зээл дээр нэрсийг иштэй нь нийлүүлж болдог боловч Японы хэрэглэгчид ишийг гүйцэд авсан байхыг шаарддаг байна. Иймд нэрсийг ишнээс нь салгах ажиллагааг хурдавчлах зорилгоор ажилтан шинээр нэмж авсан боловч үйлдвэрлэлийн төлөвлөгөө сулрах шинжтэй байгаа байдлыг анхааран үзэж, Японы үйлдвэрлэл, чанарын стандартыг хангахын тулд тус компанид шинэ тоног төхөөрөмж нийлүүлэхэд ЭЗБШӨЧ төслөөс дэмжлэг үзүүлээ. 2007 оны 1 дүгээр сард эцсийн хяналтын ажиллагаа дуусч, эхний чингэлэг ачигдлаа.

“Энэ магадгүй тийм ч их хэмжээний захиалга биш байж болох юм. Гэхдээ дотоодын нийлүүлэгчид Япончуудыг үнэнч, найдвартай түнш гэж үнэлдэг тул тэдний бизнесийн харилцаа үргэлжлэнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ захиалга нь их хэмжээний захиалгын эхнийх нь болов уу гэж найдаж байна. Бидний энэ туршилт бүтээгдэхүүнийг амжилттай экспортлоход ямар их хүч чармайлт гаргадгийг харуулсан чухал жишээ боллоо” гэж энэхүү төслийг удирдан зохицуулж буй ЭЗБШӨЧ төслийн Бизнесийн хөгжлийн зөвлөх Д.Жигжидмаа яриу.

Монгол Улсын ерөнхийлөгч Н. Энхбаяр Япон улсад айлчлах үеэрээ Pacific Trading-ийн тэргүүн ноён Норио Идэтэй уулзахаар төлөвлөжээ. Уулзалтын өмнө нэрсний чанамал Япон улсад экспортлосон тухай мэдээ Ерөнхийлөгчийн сонорт хүрсэн бөгөөд Монголын худалдааны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтаж буй Бенедакт ХХК-ийн гүйцэтгэх захирал хатагтай Д.Тунгалаг энэхүү нэрсний төслийн талаар танилцуулга хийх юм.

Зээлийн мэдээллийн санг хувьчлах ажлыг Монголын Банкуудын холбоо удирдаж байна

Одоогийн Зээлийн мэдээллийн сангийн (ЗМС) үйлчилгээг сайжруулах боломжийн талаар санал солилцох уулзалтыг Монголын банкуудын холбооноос (МБХ) энэ оны 2 дугаар сарын 28-нд банкуудын удирдах ажилтнуудын дунд зохион байгуулав.

Арилжааны 9 банк, банк бус санхүүгийн 2 байгууллага, МБХ-ны удирдлага, ЭЗБШӨЧ төслийн төлөөлөгчид уг уулзалтанд оролцлоо. ЗМС-гийн өнөөгийн нөхцөл байдлын талаар манай төслөөс товч танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар оролцогчид саналаа солилцов. Үүнээс гадна зээлийн мэдээллийн үйлчилгээг үзүүлэх хувийн компанийг байгуулах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулах асуудлаар уулзалтанд оролцогчид санал нэгдэн, Монгол Банк, ХАС Банк, Худалдаа,

хөгжлийн банк, Капитрон банк, МБХ-ны төлөөлөгчдөөс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулахаар тохиролцлоо.



Одоогийн ЗМС-гийн хэрэглэгчдэд санамж бичигт нэгдэх боломж нээлттэй бөгөөд компани байгуулагдан, удирдах зөвлөлийн гишүүд сонгогдох хүртэл ажлын хэсэг үйл ажиллагаагаа явуулах болно. Ажлын хэсэг дараах ажлыг гүйцэтгэх юм. Үүнд:

- Бизнес төлөвлөгөө боловсруулах
- Монгол Банкныг шинээр байгуулах компаний хувьцаа эзэмшигчээр оролцуулах талаар тохиролцох
- Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хувийн компани шинээр байгуулахын оронд одоогийн ЗМС-г хувьчлах стратегийн шийдвэрийн талаар зөвлөмж гаргах
- ЗМС-гийн хувьцаа эзэмшигчээр хэн байж болох, мэдээллийг хэн ашиглах талаар зөвлөмж гаргах
- Компаний бүтцийн талаар санал боловсруулах
- Санхүү, техникийн туслалцаа авах талаар стратегийн түншүүдтэй холбоо тогтоон, ярилцаж тохирох
- Санамж бичигт гарын үсэг зурагсдад сар тутам явцын талаар мэдээлж байх

Зээлийн мэдээллийн сангийн өнөөгийн нөхцөл байдлын талаар товч

Банк, банк бус санхүүгийн байгууллага, нийтийн аж ахуйн нэгж, МБХ, Монгол Банк зэрэг газруудын 80 гаруй төлөөлөгчид оролцсон уулзалтыг уг төслөөс 2005 оны 11 дүгээр сард зохион байгуулж ивээн тэтгэсэн билээ. Уулзалтын зорилго нь ЗМС-гийн талаар Монгол Банкны тавих илтгэлийг сонсох, сангийн цаашдын хөгжлийн төлөвлөгөөний талаар санал солилцох, сангийн ирээдүйн талаар нээлттэй хэлэлцүүлэг явуулахад оршиж байв. Зээлийн мэдээлэл цуглуулах, солилцох механизм оновчтой бус, бизнес загвар зохистой бус, Монгол Банк сангийн үйл ажиллагааг удирдах нь буруу гэсэн асуудал дээр уулзалтанд оролцогчид санал нэгдэв. Харин санг хэн удирдах, заавал гишүүн байх эсэх, сангийн бизнес загвар ямар байх талаар тодорхой саналд хүрсэнгүй. Хурлын үеэр Монгол Банк ЗМС-г хувийн хэвшлийнхэнд шилжүүлэхэд бэлэн байгаагаа мэдэгдэв. Монгол Банк, хувийн хэвшил болон сонирхогч талуудын тавьсан хүсэлтийн дагуу манай төслөөс техник, эдийн засгийн судалгаа хийж, боломжит хувилбаруудын талаар санал боловсруулахаар болов.

2006 оны 6 дугаар сарын эхээр ЗМС-гийн олон улсын шинжээч Рожер Най Монгол улсад ажиллан, дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

- Одоогийн ЗМС-гийн үйл ажиллагаа, санхүүгийн байгууллага ба бусад зээл олгогчдын тавьж буй шаардлага, эрх зүй, зохицуулалтын орчинг хянан дүн шинжилгээ хийх, бизнесийн тохиромжтой загварыг санал болгох, зээлийн мэдээлэл солилцоход тавигдаж буй

шаардлагыг хангахын тулд эрх зүйн зохицуулалтыг сайжруулах талаар зөвлөмж гаргах

- ЗМС шинээр байгуулах эсвэл одоогийн ЗМС-г хувьчлах арга зам, авах арга хэмжээний талаар зөвлөмж гаргах байдлаар хувийн хэвшил болон Монгол Банкнд дэмжлэг үзүүлэх.

Ноён Най 40 гаруй уулзалт, ярилцлага хийсний эцэст ЗМС-гаас авч буй мэдээллийг банкны салбар үнэлдэг нь маргаангүй бөгөөд харин ЗМС-г цаашид сайжруулахад ялангуяа техникийн чадавхийг дээшлүүлэх, мэдээллийн санг баяжуулах шаардлагатай гэсэн бодолтой юм байна гэсэн дүгнэлтийг хийв. Монгол Банк, зээлдүүлэгчид, хувьцаа эзэмшигчдийн олонхи нь ЗМС-г хувьчлах саналыг дэмжиж байв. Гэхдээ хувьчлах хугацааны талаар тохиролцоонд хүрээгүй бөгөөд сангийн үйл ажиллагааг цаашид удирдан чиглүүлэх хүсэл, сонирхолтой банк гарсангүй. ЗМС банкуудын мэдэлд байх ёстой гэж банкууд үзэж байгаа боловч ямар ч банк одоогийн байдлаар хөрөнгө оруулах хүслээ илэрхийлсэнгүй. МБХ санг удирдах үүрэг хүлээхээс мөн татгалзав.

ЗМС-д тулгарч буй нэн чухал дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх хувьцаа эзэмшигчдийн ажлын хэсгийг нэн даруй байгуулахыг ноён Най санал болгосон. Үүнд:


- Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ба оролцогч талуудыг тогтох
- Бизнес төлөвлөгөө боловсруулах
- ЗСМ-г хэзээ хувьчлахыг шийдвэрлэх
- Мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдал, нууцлалыг хангаж мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлэх
- Сангийн үйл ажиллагааг эхлүүлэхэд гадаадын байгууллагуудаас техникийн туслалцаа авах

Зээлийн хүрээг эрс нэмэгдүүлэх нь банкуудын зээлийн эрсдлийг бууруулахад чиглэсэн эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чухал бөгөөд зээлийн мэдээллийн үйлчилгээг сайжруулах талаар санал нэгдэж буй явдал мөн ач холбогдолтой юм. Энэ ажлыг МБХ-оор дамжуулан мөн Ажлын хэсэг байгуулах замаар шуурхайлахаар уулзалтад оролцогсод шийдсэн бөгөөд манай төслөөс туслалцаа үзүүлэх боломжийг эрэлхийлэхээр шийдвэрлэв.

ҮТЕГ-аас татварын шинэчлэгдсэн маягтуудыг зааврын хамт англи хэл дээр нийтлэн гаргалаа

Үндэсний Татварын Ерөнхий Газар (ҮТЕГ) манай төслийн туслалцаатайгаар Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиудыг багтаасан товхимлуудыг англи хэл дээр нийтлэн гаргалаа.

Эдгээр товхимлуудыг ҮТЕГ-аас монгол хэл дээр 1 дүгээр сард хэвлэн гаргаж, орон нутаг дах татварын албадаараа дамжуулан 23,000 хувийг татвар төлөгчдөд зориулан тараажээ. Энэ товхимол нь 2007 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөгдөж буй татварын шинэ хуулиудыг олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээний хүрээнд татвар






төлөгчдийн гарт очиж буй мэдээллийн чанартай анхны баримт бичиг юм.

Эдгээр товхимлуудад татварын шинэ, хуучин хуулийн ялгааг хүснэгтээр харуулж, татварын тайлан гаргах шинэ маягтуудыг зааврын хамт багтааснаараа онцлог юм.

Товхимлуудыг англи хэл дээр хэвлэн, татварын хуулинд орсон өөрчлөлт шинэчлэлүүдийн талаар хөрөнгө оруулагчид ба гадаадын татвар төлөгчдөд танилцуулах нь чухал ач холбогдолтой билээ.

Товхимлуудын электрон хувилбаруудыг дараах вэб сайтуудаас монгол, англи хэл дээр үзэх боломжтой: ҮТЕГ-ын вэб сайт (www.mta.mn); ЭЗБШӨЧ төслийн вэб сайт (www.eprc-chemonics.biz).

Үүнээс гадна уг төслийн дэмжлэгтэйгээр ҮТЕГ-аас татварын шинэ хуулиудыг нэгтгэсэн тусгай товхимлыг англи хэлтэй хэрэглэгчдэд зориулан гаргасан.



Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны тухайн сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтийг ЭЗБШӨЧ төслийн цувралын эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү. И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.